



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 13, 15140-0036  
Утас/Факс: (976-11) 31-83-92  
E-mail: nok@ulaanbaatar.mn  
<http://www.nobg.ub.gov.mn>

2021.09.10 № 593

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Нийслэл хотод коронавируст халдвар (Ковид-19)-ын дельта хувилбарын тархалт, халдвар нэмэгдэж байгаатай холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагууд халдвараас сэргийлэх, батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед авах хариу арга хэмжээний түр зааварчилгааг хүргүүлж байна.

Хэрэгжүүлж ажиллана уу.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ХУРАНДАА



Д.ОЮУНБАТ

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗРЫН ОРЛОГЧ  
ДАРГА Ж.ОТГОНБОЛД

2021 оны 09 дугаар сарын 09 өдөр

## КОРОНАВИРУСТ (КОВИД-19) ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ХАЛДВАРЫН БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛ ИЛЭРСЭН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗААВАРЧИЛГАА

Нийслэл хотод коронавируст халдвар (КОВИД-19)-ын дельта хувилбарын батлагдсан тохиолдлын тоо эрс нэмэгдэж, цаашид халдварын тохиолдол өсөх эрсдэл өндөр байгаа тул байгууллага, аж ахуйн нэгжүүдэд халдвараас сэргийлэх, ажилтан, албан хаагчдын дунд батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед халдвар голомтлон гарах эрсдэлийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээнд энэхүү түр зааварчилгааг мөрдлөг болгоно.

Нэг. Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ажилтан албан хаагч, үйлчлүүлэгчдэд зориулан коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх талаарх мэргэжлийн байгууллагаас гаргасан зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг зэргийг нүдэнд харагдахуйц газар байрлуулах,

1.1.Засгийн газраас гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тохиолдолд ажилтан албан хаагчдын 10-30 хүртэлх хувийг ажиллуулж, бусдыг цахимд шилжүүлэх,

1.2.Ажилтан, алба хаагчид нь амны хаалт тогтмол зүүх, амны хаалтаа 2 цаг тутамд болон бохирдсон тухай бүр сольж, хогийн саванд хаях,

1.3.Ажлын байранд хүн хоорондын зайг 1-2 метрт барих, олноороо нэг дор бөөгнөрч цугларах, ажлын байранд хамтарч хооллох, цай уухыг хориглох,

1.4.Ажилтан албан хаагчдад гар угаах, гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангах

1.5.Ажлын байранд гадны хүн орохыг хориглох ба шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтныг дуудаж үйлчлүүлэх, хүлээн авч уулзах цэгийг тусад нь гаргах,

1.6.Ажлын зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд бусад өрөөгөөр орохгүй байх, асууж тодруулах зүйл байвал утсаар холбогдоно.

1.7.Ажлын байранд агаар сэлгэлтийг тогтмол хийх,

1.8.Ажлын байранд тогтмол хугацаанд халдваргүйжүүлэлт хийлгэж байх,

1.9.Ажилтан албан хаагчдыг коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад бүрэн хамруулах,

1.10.Ажилтан, албан хаагчдад айл хэсэхгүй, зочин урихгүй байх, “гэр-ажил” маршрутаар зорчих зөвлөмж өгөх.

Хоёр. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед халдвар голомтлон гарах эрсдэлийг бууруулах, таслан зогсоох талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



2.1. Хэрэв ажилтан, албан хаагч нь коронавируст халдвар батлагдсан бол энэ тухай байгууллагын удирдах албан тушаалтанд шуурхай мэдээлнэ.

2.2. Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд халдвар батлагдсан тохиолдолд ажлын байранд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ.

2.3. Хэрэв тухайн байгууллагаас нэг өрөөнөөс 2-оос дээш батлагдсан тохиолдолд тухайн өрөөний ажилтнуудыг, бусад өрөөнүүдээс алаг цоог халдвар илэрсэн тохиолдолд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг цахимд шилжүүлнэ.

2.4. Дээрх тохиолдолд байгууллагын ажилтан албан хаагчид нь халдвар хамгааллын дэглэмээ чанд мөрдөх, биеийн байдлаа ажиглах, хэрэв халуурах, ханиалгах, хоолой өвдөх, үнэр амт мэдрэхүй алдагдах, хамар битүүрэх, амьсгаадах, бөөлжих, суулгах зэрэг шинж илэрвэл байгууллагын удирдах албан тушаалтанд мэдэгдэж, ажилдаа ирэхгүй байх, оршин суугаа хаягийн дагуу өрхийн эмнэлэгт хандаж зөвлөгөө авна.

2.5. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 43 дугаар тушаалд заасны дагуу сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн ажилтан, албан хаагчаас халдвар илрүүлэх бх-ПГУ болон антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний “сөрөг” хариу шаардахгүй.

2.6. Асрамжийн газар, цэргийн анги, хорих, саатуулах байр, уул уурхайн кемп зэрэг хаалттай орчинд эрүүл мэндийн байгууллагын мэргэжил арга зүйн удирдлаган дор идэвхтэй тандалт, хариу арга хэмжээг зохион байгуулна:

2.6.1. Эрүүл мэндийн Сайдын 2021 оны “Түр зааврыг шинэчлэн батлах тухай” А/456 тушаалд “халдварын шинж тэмдэг илэрч түргэвчилсэн шинжилгээний хариу “сөрөг” гарсан тохиолдолд бх-ПГУ шинжилгээнд хамруулж болно. Тандалтын зорилгоор ажилтнуудын 20-30 хувьд 14 хоногийн давтамжтайгаар түргэвчилсэн шинжилгээ хийнэ” гэж заасныг мөрдөх ба Монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн антиген суурьтай түргэвчилсэн оношлуурыг хэрэглэнэ.

2.6.2. Тухайн байгууллагад халдварын батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй, асуумжаар ойрын хавьтал болсон ажилтан, албан хаагч байхгүй, эмнэл зүйн шинж тэмдэг илрээгүй зэрэг тохиолдолд халдвар илрүүлэх шинжилгээг хийхгүй.